ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**Аудитын код:** ДГА-2026/79/НА-СТА-ТШЗ


| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn | Дарга, тэргүүлэх аудитор: | Т.Ган-Өлзий |
| Сайншанд сум | Цахим хаяг: | dornogovi@audit.gov.mn |
| 2026 он | Аудитын менежер: | У.Оюунтүлхүүр |
| | Цахим хаяг: | oyuntulkhuur.u@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: | О.Нарангарав |
| | Цахим хаяг: | narangarav.o@audit.gov.mn |
| | Аудитор: | А.Дамчой |
| | Цахим хаяг: | damchoia@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.06 № 1-6/36

танай_____________-ны №______________-т

ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.СҮГЛЭГМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон 24.2 сая төгрөгийн санхүүжилтийг сумын ОНХС-д төвлөрүүлэх байтал Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5, 60.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

442505008

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **121,588,719.97** | **164,771,536.32** |
| 33 | АВЛАГА | 10,777,839.10 | 42,050,429.50 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 114,873.60 | - |
| 335 | Бусад авлага | 10,662,965.50 | 42,050,429.50 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,662,965.50 | 42,050,429.50 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 110,810,880.87 | 122,721,106.82 |
| 351 | Түүхий эд материал | 5,251,030.62 | 1,820,647.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,251,030.62 | 835,647.00 |
| 35130 | Эм боох материал | - | 985,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 105,559,850.25 | 120,900,459.82 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,013,680.00 | 4,090,560.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 45,617,170.25 | 50,349,899.82 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 16,679,000.00 | 17,054,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 39,250,000.00 | 49,406,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,185,402,462.89** | **3,169,176,522.03** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,185,402,462.89 | 3,169,176,522.03 |
| 392 | Биет хөрөнгө | 3,112,488,296.49 | 3,094,799,022.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,214,971,594.00 | 2,214,971,594.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (285,732,524.64) | (366,759,591.96) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 662,217,925.00 | 751,277,925.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (369,821,571.82) | (425,242,657.12) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 142,112,192.30 | 128,245,027.41 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (96,440,795.38) | (29,963,880.18) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 190,791,919.80 | 162,403,264.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (84,634,357.19) | (43,026,286.66) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,373,831,916.01 | 1,242,319,395.31 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (634,808,001.59) | (539,425,767.45) |
| 393 | Биет бус хөрөнгө | 72,914,166.40 | 74,377,499.68 |
| 39301 | Программ хангамж | 3,566,000.00 | 1,830,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,457,833.60) | (258,500.32) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 72,806,000.00 | 72,806,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,306,991,182.86** | **3,333,948,058.35** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,887,386.00** | 19,448,570.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,887,386.00 | 19,448,570.00 |
| 413 | Өглөг | 2,887,386.00 | 19,448,570.00 |
| 4136 | Бусад өглөг | 2,887,386.00 | 19,448,570.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,887,386.00 | 19,448,570.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,304,103,796.86** | **3,314,499,488.35** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,304,103,796.86 | 3,314,499,488.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 942,714,114.56 | 942,714,114.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 942,714,114.56 | 942,714,114.56 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,818,460,321.82 | 1,828,856,013.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,818,460,321.82 | 1,818,460,321.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 10,395,691.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 542,929,360.48 | 542,929,360.48 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,306,991,182.86** | **3,333,948,058.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,122,468,558.66** | **1,424,159,582.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 573,389,599.00 | 229,300,962.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 573,389,599.00 | 229,300,962.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 573,389,599.00 | 229,300,962.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,664,950.00 | 1,417,500.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 571,724,649.00 | 222,688,462.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 5,195,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,549,078,959.66 | 1,194,858,620.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 700,334,447.00 | 230,708,924.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 675,098,000.00 | 33,106,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,236,447.00 | 197,602,924.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 848,744,512.66 | 964,149,696.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 848,744,512.66 | 964,149,696.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,585,224,116.00** | **1,412,675,186.11** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,585,224,116.00 | 1,412,675,186.11 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,584,424,116.00 | 1,388,271,074.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 538,976,823.00 | 686,469,157.00 |
| 210101 | Үндсэн цалин | 307,696,832.20 | 358,869,674.00 |
| 210102 | Нэмэгдэл | 198,157,690.80 | 256,631,133.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,380,000.00 | 44,590,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,742,300.00 | 26,378,350.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,725,520.98 | 84,594,344.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,987,771.51 | 58,300,362.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,343,904.97 | 6,852,266.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,952,907.42 | 3,909,044.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,256,506.43 | 3,103,894.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,184,430.65 | 12,428,776.68 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,593,213.68 | 99,946,753.65 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,666,530.68 | 11,559,663.65 |
| 210302 | Түлш, халаалт | 83,103,295.00 | 85,467,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,823,388.00 | 2,919,290.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 191,268,545.73 | 69,693,386.05 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,300,440.00 | 5,252,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 102,226,972.00 | 34,720,662.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,688,270.00 | 3,121,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 76,052,863.73 | 26,598,304.05 |
| 2105 | Нормативт зардал | - | 4,056,340.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 850,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 2,406,340.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 2,162,640.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,088,500.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 74,140.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,051,000.00 | 4,094,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,051,000.00 | 4,094,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 449,188,880.00 | 177,061,254.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 448,066,352.00 | 175,945,444.23 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 445,950.00 | 339,120.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 82,520.00 | 128,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 59,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 144,058.00 | 589,690.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 238,620,132.61 | 260,193,198.46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 119,500.00 | 9,367,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 450,000.00 | 250,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 238,050,632.61 | 250,575,698.46 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 800,000.00 | **24,404,111.87** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 800,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт | - | 24,404,111.87 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 24,404,111.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(34,480,206.34)** | **11,484,395.89** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 45,011,680.60 | 1,088,704.40 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 45,011,680.60 | 1,088,704.40 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(45,011,680.60)** | **(1,088,704.40)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(79,491,886.94)** | **10,395,691.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,566,114,708.16** | **1,196,276,120.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,664,950.00 | 1,417,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,664,950.00 | 1,417,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,664,950.00 | 1,417,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,664,950.00 | 1,417,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,564,449,758.16 | 1,194,858,620.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 715,705,245.50 | 230,708,924.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 675,098,000.00 | 33,106,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 40,607,245.50 | 197,602,924.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 848,744,512.66 | 964,149,696.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 848,744,512.66 | 964,149,696.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,345,133,742.66** | **1,183,526,120.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,345,133,742.66 | 1,183,526,120.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,344,333,742.66 | 1,127,734,544.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 537,210,853.49 | 687,202,669.60 |
| 210101 | Үндсэн цалин | 298,690,077.00 | 350,129,747.75 |
| 210102 | Нэмэгдэл | 206,748,886.29 | 270,225,006.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,719,797.20 | 43,702,072.00 |
| 210104 | Урамшуулал | 13,052,093.00 | 23,145,843.85 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,556,637.49 | 84,594,330.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,001,940.32 | 58,354,940.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,336,062.03 | 6,868,106.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,388,856.21 | 3,727,729.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,189,363.24 | 3,206,857.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,640,415.69 | 12,436,697.18 |

| | | | |
|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 109,866,593.68 | 100,020,893.65 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,666,530.68 | 11,559,663.65 |
| 210302 | Түлш, халаалт | 98,269,755.00 | 85,467,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,930,308.00 | 2,993,430.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 56,993,902.00 | 28,716,282.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,295,000.00 | 3,408,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,667,672.00 | 19,275,882.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,231,230.00 | 3,923,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,800,000.00 | 2,108,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 600,000.00 | 4,226,340.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 1,835,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 2,391,340.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,203,450.00 | 2,928,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000.00 | - |
| 210602 | Тавилга | 1,584,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 8,599,450.00 | 2,928,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,051,000.00 | 4,094,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,051,000.00 | 4,094,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 549,463,806.00 | 210,484,028.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 548,791,278.00 | 209,957,908.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 445,950.00 | 339,120.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 82,520.00 | 128,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 59,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 144,058.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,387,500.00 | 5,467,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,487,500.00 | 5,217,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 900,000.00 | 250,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 800,000.00 | 55,791,575.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 800,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт | - | 55,791,575.87 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 55,791,575.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **220,980,965.50** | **44,137,464.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **210,318,000.00** | **12,750,000.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 210,318,000.00 | 12,750,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 210,318,000.00 | 12,750,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 210,318,000.00 | 12,750,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(210,318,000.00)** | **(12,750,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **10,662,965.50** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 942,714,114.56 | 542,929,360.48 | 1,326,227,559.76 | 2,811,871,034.80 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 942,714,114.56 | 542,929,360.48 | 1,326,227,559.76 | 2,811,871,034.80 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 492,232,762.06 | 492,232,762.06 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 942,714,114.56 | 542,929,360.48 | 1,818,460,321.82 | 3,304,103,796.86 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 942,714,114.56 | 542,929,360.48 | 1,818,460,321.82 | 3,304,103,796.86 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 942,714,114.56 | 542,929,360.48 | 1,818,460,321.82 | 3,304,103,796.86 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 10,395,691.49 | 10,395,691.49 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 942,714,114.56 | 542,929,360.48 | 1,828,856,013.31 | 3,314,499,488.35 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,047,889,500.00** | **941,163,084.13** | **106,726,415.87** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,047,889,500.00 | 941,163,084.13 | 106,726,415.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,047,489,500.00 | 941,163,084.13 | 106,326,415.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 725,693,000.00 | 687,202,669.60 | 38,490,330.40 |
| 210101 | Үндсэн цалин | 374,009,800.00 | 350,129,747.75 | 23,880,052.25 |
| 210102 | Нэмэгдэл | 286,243,100.00 | 270,225,006.00 | 16,018,094.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 42,500,000.00 | 43,702,072.00 | (1,202,072.00) |
| 210104 | Урамшуулал | 22,940,100.00 | 23,145,843.85 | (205,743.85) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 90,711,600.00 | 84,594,330.88 | 6,117,269.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,403,800.00 | 58,354,940.01 | 2,048,859.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,576,900.00 | 6,868,106.17 | 708,793.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,788,500.00 | 3,727,729.99 | 60,770.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,788,500.00 | 3,206,857.53 | 581,642.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,153,900.00 | 12,436,697.18 | 2,717,202.82 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 102,866,700.00 | 100,020,893.65 | 2,845,806.35 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,871,400.00 | 11,559,663.65 | 1,311,736.35 |
| 210302 | Түлш, халаалт | 85,608,800.00 | 85,467,800.00 | 141,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,386,500.00 | 2,993,430.00 | 1,393,070.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 41,253,500.00 | 22,186,520.00 | 19,066,980.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,289,100.00 | 3,408,550.00 | 3,880,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,742,400.00 | 12,942,620.00 | 12,799,780.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,282,000.00 | 3,923,750.00 | 358,250.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,000.00 | - | 140,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,800,000.00 | 1,911,600.00 | 1,888,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,040,000.00 | 14,178,500.00 | 10,861,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,250,000.00 | 11,250,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 13,790,000.00 | 2,928,500.00 | 10,861,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,610,500.00 | 4,094,000.00 | 14,516,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,610,500.00 | 4,094,000.00 | 14,516,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,814,200.00 | 23,418,670.00 | 14,395,530.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,692,200.00 | 22,892,550.00 | 12,799,650.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 230,000.00 | - | 230,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 340,000.00 | 339,120.00 | 880.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 882,000.00 | 128,000.00 | 754,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 70,000.00 | 59,000.00 | 11,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 600,000.00 | - | 600,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,500,000.00 | 5,467,500.00 | 32,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,250,000.00 | 5,217,500.00 | 32,500.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 250,000.00 | 250,000.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 400,000.00 | - | 400,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 400,000.00 | - | 400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | - | 400,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,047,889,500.00** | **941,163,084.13** | **106,726,415.87** |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,046,889,500.00 | 939,745,584.13 | 107,143,915.87 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,046,889,500.00 | 939,745,584.13 | 107,143,915.87 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,000,000.00 | 1,417,500.00 | (417,500.00) |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,417,500.00 | (417,500.00) |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **199,321,460.00** | **(199,321,460.00)** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 199,321,460.00 | (199,321,460.00) |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 199,321,460.00 | (199,321,460.00) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 6,529,762.00 | (6,529,762.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 6,333,262.00 | (6,333,262.00) |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 196,500.00 | (196,500.00) |
| 2105 | Норматив зардал | - | 4,226,340.00 | (4,226,340.00) |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 1,835,000.00 | (1,835,000.00) |
| 210502 | Хоол, хүнс | - | 2,391,340.00 | (2,391,340.00) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 188,565,358.00 | (188,565,358.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 188,565,358.00 | (188,565,358.00) |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **230,708,924.00** | **(230,708,924.00)** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 230,708,924.00 | (230,708,924.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 33,106,000.00 | (33,106,000.00) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 197,602,924.00 | (197,602,924.00) |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5.5 сая төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад 5.5 сая төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

1.Аймгийн Засаг даргаас 2024 онд хандиваар өгсөн 4.0 сая төгрөгийн 2 ширхэг суурин компьютерыг байгууллагын данс бүртгэлд бүртгэлгүй ашиглаж байсан байна. /Завсрын аудитаар/

2.Гэрэл цахилгааны зардалд үүссэн 1.0 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаж, тайлагнаагүй байна. /Завсрын аудитаар/

3.Тайлант онд 0.5 сая төгрөгийн 3 гүйлгээг санхүүгийн үр дүнгийн тайланд бодит зардлаар бүртгэж, тайлагнаагүй байна.

Аудитаар нийт 25.2 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 24.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1.0 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 25.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9.4 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1.“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон 24.2 сая төгрөгийн санхүүжилтийг сумын ОНХС-д төвлөрүүлэх байтал Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

### 3.2 Албан шаардлага

1. Иххэт сумын Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/82 дугаар захирамжаар тус суманд зохион байгуулагдсан аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээний шагналын зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Тодруулгатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ нэмэлт тодруулгын тайлан бэлтгээгүй, хавсаргаагүй нь үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ”, 16 дугаар зүйлийн 16.1.2-д “Санхүүгийн зах зээлийг хянах, зохицуулах эрх бүхий төрийн байгууллага нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаар нэмэлт тайлбар, тодруулга шаардах эрхтэй”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын нэгдүгээр хавсралт, УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад “Санхүүгийн тайлан нь УСНББОУС-тай нийцдэг бол байгууллага нь ийм нийцлийн талаарх дэлгэрэнгүй, тодорхой мэдэгдлийг уг санхүүгийн тайлангийн тодруулгад илэрхийлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Байгууллагын 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргахдаа нэмэлт тодруулгын тайланг хамт бэлтгэж, Төрийн аудитын байгууллагад ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор албан тоотоор ирүүлнэ үү.

2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>* Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 198 нэр төрлийн 1,831 ширхэг 567.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 *“Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”*, 31.3.3 *“Засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах”* гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй хөрөнгийг актлах, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоох талаар хууль, журмын хүрээнд холбогдох газарт хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлэх. /Завсрын аудит/

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хандиваар ирсэн 2 ширхэг суурин компьютерыг байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна. | 1 | 4,000.0 | 1 | 4,000.0 | - | - | 1 | 4,000.0 | - | - | - | - |
| Гэрэл цахилгааны зардлын 1.0 сая төгрөгийн өглөгийг тайлагнаагүй. | 1 | 993.2 | 1 | 993.2 | - | - | 1 | 993.2 | - | - | - | - |
| 0.5 сая төгрөгийн зардлыг бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй. | 1 | 522.1 | - | - | 1 | 522.1 | 1 | 522.1 | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **5,515.3** | **2** | **4,993.2** | **1** | **522.1** | **3** | **5,515.3** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын ОНХС-д төвлөрүүлэх санхүүжилтийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. | 1 | 24,185.9 | 1 | 24,185.9 | - | - | - | - | - | - |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг шийдвэрлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Санхүүгийн тайлан тодруулгыг иж бүрэн тайлагнаагүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **3** | **24,185.9** | **1** | **24,185.9** | **-** | **-** | **2** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасныг зөрчсөн байна. | 1 | 1,000.0 | - | - | 1 | 1,000.0 | - | - |
| **Дүн** | 1 | 1,000.0 | - | - | 1 | 1,000.0 | - | - |
| **Нийт дүн** | **1** | **1,000.0** | **-** | **-** | **1** | **1,000.0** | **-** | **-** |